



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ  
ГАЗАР

Нийслэлийн засаг захиргааны IV байр,  
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот, 15160-0066  
Утас:(976) 7575 7807, Факс: (976) 7575 7809  
Цахим шуудан: contact@ub-procurement.mn  
Цахим хаяг: www.ub-procurement.mn

2024.07.29 № 03/1412

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Тодруулга оруулах тухай

Тус газраас 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдөр зарласан Нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх "Авто зам, замын байгууламжийн засвар шинэчлэлт"-ийн төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын зураг, төсвийг хүргүүлж байна. Тендер шалгаруулалтын баримт бичигт өөрчлөлт оруулж байгаатай холбогдуулан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь заалтын дагуу дараах өөрчлөлтийг оруулж байна.

№	Тендер шалгаруулалтын баримт бичгийн заалт	Орсон өөрчлөлт
1	Тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 26.1 дэх заалт: Тендер хүлээн авах эцсийн хугацаа 2024 оны 08 дугаар сарын 05-ны өдөр гэснийг;	Тендерийн хүлээн авах эцсийн хугацаа 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдөр гэж;
2	Тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 26.2 дахь заалт: Тендерийн нээлт хийх хугацаа 2024 оны 08 дугаар сарын 05-ны өдөр гэснийг;	Тендерийн нээлт хийх хугацаа 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдөр гэж;

Мөн төсөл, арга хэмжээний зураг төслийн үнэ барилгын ажлын төсөвт тусгагдсан тул тендерийн үнийн саналд зураг төсвийн үнийг багтаан ирүүлэх болохыг анхаарна уу.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т заасны дагуу тодруулгыг цахим системд нээлттэй байршуулснаар сонирхогч этгээдэд хүргүүлсэнд тооцно.

Жич: Тендер хүлээн авах эцсийн хугацаа, тендерийн нээлт хийх хугацааны цаг, минутад ямар нэгэн өөрчлөлт ороогүй болно.